



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийг газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БӨА-2021/14/НА- СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Өлгий хот

2022 он

Төрийн аудитын газрын дарга бөгөөд
тэргүүлэх аудитор: М.Хуанган

Утас: 70422954

Цахим хаяг: huanganm@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Женисбек

Утас: 70422930

Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn

“Уужим алтай Адит” ХХК-ны аудитор: Х.Тилекберди

Утас: 95405553

Цахим хаяг: htilekberdi@yahoo.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	Error! Bookmark not defined.
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	Error! Bookmark not defined.
3. Аудитын тайлан.....	Error! Bookmark not defined.
3.1 Ерөнхий зүйл.....	Error! Bookmark not defined.
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	Error! Bookmark not defined.
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	Error! Bookmark not defined.
3.4 Материаллаг байдал	Error! Bookmark not defined.
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	Error! Bookmark not defined.
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	Error! Bookmark not defined.
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	Error! Bookmark not defined.
3.8 Аудитын гол асуудал	Error! Bookmark not defined.
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	Error! Bookmark not defined.
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	Error! Bookmark not defined.
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	Error! Bookmark not defined.
4. Аудитын илрүүлэлт	Error! Bookmark not defined.
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	Error! Bookmark not defined.



**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgiiaudit.gov.mn

ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН
ХӨГЖЛИЙН ГАЗРЫН
ДАРГА Х.ПЕРНЕГУЛ ТАНАА

᠒᠐21.᠐᠔.25 № 219
танай _____-ны № _____-т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Дүгнэлт ГБХЗХГазар

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  М.ХУАНГАН

Сум дундын ойн анги-дүгнэлт

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/			
Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1333019.28</u>	<u>1332000.00</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	1019.28	
311	Кассанд байгаа бэлэн мөнгө		
31110	Төгрөг		
31130	Нэмэлт санхүүжилт		
31140	Касс арилжааны банк		

Аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийг газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

312	Банкинд байгаа бэлэн мөнгө	1019.28	
3121	Төгрөг	1019.28	
31211	Төрийн сангийн харилцах		
31213	Арилжааны банк дахь харилцах	1019.28	
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах		
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах		
31216	Нэмэлт санхүүжилтийн арилжааны банк		
33	АВЛАГА		
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага		
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага		
33300	Татаас, санхүүжилтийн авлага		
33400	Зээлийн хүүгийн авлага		
335	Бусад авлага		
3351	Байгууллагаас авах авлага		
3352	Хувь хүмүүсээс авах авлага		
35	БАРАА МАТЕРИАЛ	1332000	1332000
351	Түүхий эд материал		
35110	Тусгай зориулалттай материал		
35130	Эм боох материал		
35200	Дуусаагүй үйлдвэрлэл		
35300	Бэлэн бүтээгдэхүүн		
354	Хангамжийн материал	1332000	1332000
35410	Бичиг хэргийн материал		
35420	Аж ахуйн материал	1332000	1332000
35430	Сэлбэг хэрэгсэл		
35440	Түлш, шатах тослох материал		
35450	Барилгын засварын материал		
35460	Хүнсний материал		
35470	Бусад хангамжийн материал		
35500	Биологийн хөрөнгө		
35600	Мал амьтад		
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>169781986.49</u>	<u>201347117.57</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	169781986.49	201347117.57
391	Газар		
392	Биет хөрөнгө	135706986.49	161125117.59
39201	Барилга, байгууламж, орон сууц	93995210.00	93995210.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-2349880.20	-3916467.00
39203	Авто-тээврийн хэрэгсэл	42000000.00	42000000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-19872222.02	-28683333.42
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	57225353.00	94085753.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-46025162.88	-46264321.14
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	23167184.00	23265084
39208	Хуримтлагдсан элэгдэл	-13192945.41	-14116257.85
39209	Зам, гүүрийн байгууламж		
39210	Хуримтлагдсан элэгдэл		
39211	Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж		
39212	Хуримтлагдсан элэгдэл		
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс		
39214	Бусад үндсэн хөрөнгө		
39215	Хуримтлагдсан элэгдэл		
39216	Дуусаагүй барилга, байгууламж		
39217	Ном	759450.00	759450.00

Аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийг газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

393	Биет бус хөрөнгө	34075000.00	40221999.98
39301	Програм хангамж	1000000.00	1000000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл		-130000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	33075000.00	39352000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл		
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>171115005.77</u>	<u>202679117.57</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		<u>36937.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		36937.00
413	Өглөг		36937.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг		36937.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг		
41330	Татаас, санхүүжилт, шилжүүлгийн өглөг		
41340	Хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон өглөг		
41350	Зээлийн хүүгийн өглөг		
4136	Бусад өглөг		
41361	Байгууллагад төлөх өглөг		
41362	Хувь хүмүүст төлөх өглөг		
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>171115005.77</u>	<u>202642180.57</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	171115005.77	202642180.57
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	80680159.00	86957159.00
51101	Өмч: - төрийн	80680159.00	86957159.00
51102	- хувийн		
51103	- хувьцаат		
51104	Халаасны хувьцаа		
51105	Нэмж төлөгдсөн капитал		
51106	Эздийн өмчийн бусад хэсэг		
512	Хуримтлагдсан үр дүн	-167932482.23	-142682307.43
51210	Өмнөх үеийн үр дүн	-167932182.23	-167932482.23
51220	Тайлант үеийн үр дүн		25250174.80
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс		
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	258367329.00	258367329.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>171115005.77</u>	<u>202679117.57</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	290770819.28	303233700.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	551019.28	
120	Нийтлэг татварын бус орлого	551019.28	
120001	Хувьцааны ногдол ашиг		
120002	Хүүгийн орлого		
120003	Торгуулийн орлого		
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	55109.28	
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		

Аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийг газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1019.28	
1200043	Урьд оны үлдэгдэлээс санхүүжих		
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих		
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	550000.00	
120005	Түрээсийн орлого		
120008	Монгол банкны ашиг		
122	Тусламжийн орлого		
122001	Хандив тусламж /дотоод/		
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	290219800,00	303233700.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс	264756400,00	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1270000.00	21500000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1270000.00	21500000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		
131106	Төсвийн урамшуулал		
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	24193400.00	16336400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	24193400.00	16336400.00
132002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт		
132003	Төвлөрүүлэх шилжүүлэг /орон нутгийн төсөвт байгууллага улсад төвлөрүүлэх орлого/		
132004	Оны эхний үлдэгдлээс санхүүжих / орон нутгийн төсөв/		
132005	Хөрөнгийн санхүүжилт / орон нутгийн төсөвт байгууллага/		36800400.00
132006	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/		228536900,00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих		
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	295142148,40	277983525,10
21	УРСГАЛ ЗАРДАЛ	295142148,40	277983525,10
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	247336421,40	277248599,20
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	106210436,00	121897402,00
210101	Үндсэн цалин	89370404,00	80758253,00
210102	Нэмэгдэл	16840032,00	19920730,00
210103	Унаа хоолны хөнгөлөлт		
210104	Урамшуулал		
210105	Гэрээт ажлын хөлс		21218419,00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	16107261,00	16320340,00
210201	Тэтгэврийн даатгал	11313921,00	11305850,00
210202	Тэтгэмжийн даатгал	946746,00	1256774,00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1025759,00	917077,00
210204	Ажилгүйдлийн даатгал	256440	335491,00
210205	Эрүүл мэндийн даатгал	2564395,00	2505148,00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	18205007,00	15145000,00
210301	Гэрэл, цахилгаан	3696000,00	440000,00
210302	Түлш, халаалт	14509007,00	14408600,00

Аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийг газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210303	Цэвэр, бохир ус		296400,00
210304	Байрны түрээс		
2104	Хангамж, бараа материалын зардал	6501450,00	17004330,00
210401	Бичиг хэрэг	2524600,00	13011150,00
210402	Тээвэр, шатахуун	3212850,00	3541800,00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	500000,00	451380,00
210404	Ном, хэвлэл		
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	264000,00	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал		
210408	Бараа материал акталсны зардал		
2105	Нормативт зардал		
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		
210502	Хоол, хүнс		
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	113100,00	1191400,00
210601	Багаж, техник, хэрэгсэл		
210602	Тавилга		
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		
210604	Урсгал засвар	113100,00	1191400,00
2107	Томилолт, зочны зардал	60000,00	1495000,00
210701	Гадаад албан томилолт		
210702	Дотоод албан томилолт	60000,00	1495000,00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	89126161,00	76702208,28
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	87840495,00	75816825,00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	150000,00	
210803	Даатгалын үйлчилгээ		
210804	Тээврийн хэрэгслийн татвар	76720,00	75344,00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44000,00	55000,00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1009767,00	754020,00
210807	Газрын төлбөр		
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	5179,00	1019,28
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх		
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11013006,40	27492918,92
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1270000,0	1557550,00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	270000,00	251200,00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	9473006,40	11670168,92
210904	Найдваргүй авлагын алдагдал	-	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	47805727,00	734926,00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг		
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг		
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг		
2132	Бусад урсгал шилжүүлэг	28967696,00	
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж		
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж		
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал		
213206	Ээлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт		

Аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийг газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	28567696,00	
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	400000,00	
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	10651325,00	734926,00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	10651325,00	734926,00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	8186706,00	
213401	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт төсөвт байгууллага		
213402	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт сумдад		
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	8186706,00	
213404	Хөрөнгийн		
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-4371329,12	25250174,80
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)		
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-4371329,12	25250174,80

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/			
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	290220819,28	266373300,00
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	290220819,28	266373300,00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1019,28	
120	Нийтлэг татварын бус орлого	1019,28	
120001	Хувьцааны ногдол ашиг		
120002	Хүүгийн орлого		
120003	Торгуулийн орлого		
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1019,28	
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1019,28	
1200043	Урьд оны үлдэгдэлээс санхүүжих		
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих		
120005	Түрээсийн орлого		
120009	Бусад орлого		
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	290219800,00	266373300,00
131007	Тусгай зориулалтын шилжүүлэг	264756400,00	228536900
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1270000,00	21500000,00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1270000,00	21500000,00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		

Аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийг газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

131106	Төсвийн урамшуулал		
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих		
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/		
132002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт		
132003	Төвлөрүүлэх шилжүүлэг /орон нутгийн төсөвт байгууллага улсад төвлөрүүлэх орлого/		
132004	Оны эхний үлдэгдлээс санхүүжих / орон нутгийн төсөв/		
132005	Хөрөнгийн санхүүжилт / орон нутгийн төсөвт байгууллага/		
132006	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/	24193400,00	16336400,00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих		
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>286992979,00</u>	<u>266276419,28</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	286992979,00	266276419,28
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	239187252,00	265541493,28
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	101014100,00	124544000,00
210101	Үндсэн цалин	73658700,00	73658700,00
210102	Нэмэгдэл	27355400,00	28238000,00
210103	Унаа хоолны хөнгөлөлт		
210104	Урамшуулал		
210105	Гэрээт ажлын хөлс		22647300,00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	13636800,00	13636800,00
210201	Тэтгэврийн даатгал	9596300,00	5294400,00
210202	Тэтгэмжийн даатгал	1010100,00	2085600,00
210203	ҮОМШӨ-ний даатгал	808100,00	1668500,00
210204	Ажилгүйдлийн даатгал	202000,00	417100,00
210205	Эрүүл мэндийн даатгал	2020300,00	4171200,00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	18205007,00	15145000,00
210301	Гэрэл, цахилгаан	3696000,00	440000,00
210302	Түлш, халаалт	14509007,00	14408600,00
210303	Цэвэр, бохир ус		296400,00
210304	Байрны түрээс		
2104	Хангамж, бараа материалын зардал	3864000,00	3551380,00
210401	Бичиг хэрэг	2500000,00	2500000,00
210402	Тээвэр, шатахуун	600000,00	600000,00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	500000,00	451800,00
210404	Ном, хэвлэл		
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	264000,00	0,00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал		
210408	Бараа материал акталсны зардал		
2105	Нормативт зардал		
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		
210502	Хоол, хүнс		
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	113100,00	1191400,00
210601	Багаж, техник, хэрэгсэл		
210602	Тавилга		
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		

Аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийг газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210604	Урсгал засвар	113100,00	1191400,00
2107	Томилолт, зочны зардал	60000,00	1495000,00
210701	Гадаад албан томилолт		
210702	Дотоод албан томилолт	60000,00	1495000,00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	100814245,00	84294613,28
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	99528579,00	83409230,00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	150000,00	
210803	Даатгалын үйлчилгээ		
210804	Тээврийн хэрэгслийн татвар	76720,00	75344,00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44000,00	55000,00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1009767,00	754020,00
210807	Газрын төлбөр		
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	5179,00	1019,28
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх		
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	47805727,00	734926,00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг		
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг		
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг		
2132	Бусад урсгал шилжүүлэг	28967696,00	
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж		
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж		
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал		
213206	Ээлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт		
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	28567696,00	
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	400000,00	
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	10651325,00	734926,00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	10651325,00	734926,00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	8186706,00	
213401	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт төсөвт байгууллага		
213402	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт сумдад		
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	8186706,00	
213404	Хөрөнгийн		
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>3227840,28</u>	<u>96880,72</u>
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>3232000,00</u>	<u>97900,00</u>
140008	Хүлээн авсан ногдол ашиг		
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	3232000,00	97900,00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3232000,00	97900,00
2200	Дотоод эх үүсвэрээр		
220001	Барилга байгууламж		
221001	Их засвар		

222001	Тоног төхөөрөмж		
223001	Бусад хөрөнгө		
224001	Стратегийн нөөц хөрөнгө		
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	3232000,00	97900,00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-3232000,00</u>	<u>-97900,00-</u>
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	≡	≡
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	--4159,72	-1019,28-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	5179,00	1019,28
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1019,28	

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /					
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	80680159,00	258367329.00	-167932428.23	171115005.77
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
C07	Тайлант үеийн үр дүн				
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл				
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	80680159,00	258367329.00	-167932428.23	171115005.77
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	80680159,00	258367329.00	-167932428.23	171115005.77
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	6277000,00			6277000.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				
D08	Тайлант үеийн үр дүн			25250174.80	25250174.80
D09	202 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	86957159,00	258367329.00	-142 682 307.43	202642180.57

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1, “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын дүгнэлт түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд цалинтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Уужим алтай Аудит” ХХК-ны аудитор Х.Тилекберди гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, газрын дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн. Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 сарын 25-ний өдрийн 22 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Байгууллагын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэл.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Бага насны хүүхдийг эрүүл бие бялдартай, саруул ухаантай, зөв хүмүүжилтэй хүн болгон төлөвшүүлэхэд эцэг эхтэй хамтран ажиллахад оршино. Гэр бүлийн тулгуур үнэт зүйлд суурилсан хүүхэд, залуучуудын хөгжил, оролцоог нэмэгдүүлэх, хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэх, эрхийг хангах, хамгааллыг бэхжүүлэх цогц бодлогыг хэрэгжүүлэх.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албанаас 2021 онд оны үйл ажиллагаанд шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузль/мөнгөн сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4. Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож,

эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны санхүүгийн тайлангийн нийт зардлын 295.1 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 4.4 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 3.3 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5. Санхүүгийн тайлангийн тодруулга

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 31.5 сая төгрөгөөр буюу 18.4 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгө, өглөг данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	1.0		-1.0
Авлага			
Урьдчилгаа			
Бараа материал	1332.0	1332.0	0.0
Үндсэн хөрөнгө	169782.0	201347.1	31565.1
Нийт хөрөнгө	171115.0	202679.1	31564.1
Өр төлбөр		36.9	36.9
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	171115.0	202642.2	31527.2
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	171115.0	202679.1	31564.1

Мөнгөн хөрөнгө, авлага данс оны эцэст үлдэгдэлгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэлд өөрчлөлт ороогүй байна. Тайлант онд 57.1 сая төгрөгийн бараа материалыг худалдан авч, зарцуулсан байна. Оны эцсийн бараа материалын үлдэгдэл аж ахуйн материалын үлдэгдэл байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 201.3 сая төгрөг болж 31.5 сая төгрөгөөр өссөн нь “НҮБ”-ын төслийн хандиваар 36.9 сая төгрөгийн хөрөнгө авсан нь нөлөөлсөн байна. Үндсэн хөрөнгөнд 11.7 сая төгрөгийн элэгдэл байгуулсан байна.

Аймгийн ИТХ-ын тогтоолын дагуу 26.6 сая төгрөгийн газар эзэмших эрхийг биет бус хөрөнгө дансанд орлогод авч, 20.3 сая төгрөгийн газрын эрхийг Татварын хэлтэст шилжүүлж хөрөнгийг данснаас хасаж, өөрчлөлт орсон байна.

Өглөг дансны үлдэгдэл оны эцэст 36.9 мянган төгрөг болж нэмэгдсэн байна. Урт хугацаат өр төлбөр байхгүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 31.5 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд 25.2 сая төгрөгийн үр дүнтэй гарсан, Засгийн газрын капиталын дүнд 6.3 сая төгрөгийн газрын эрхийн өөрчлөлт орсонтой холбоотой нэмэгдсэн байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар үр дүн 25.2 төгрөг байна. Өмнөх оны үр дүнд ямар нэгэн залруулга хийгдээгүй байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 12.4 сая төгрөгөөр буюу 4.2 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан санхүүжилтийн орлого, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого байна.

Нийт зардал өмнөх оноос 17.0 сая төгрөгөөр буюу 5.8 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалингийн болон бусад зардал байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын төсвийг Аймгийн ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 09-ны өдрийн 16 дугаар тогтоолоор 244.8 сая төгрөгөөр баталж, Аймгийн ИТХ-ын 2021 оны 8 дугаар сарын 09-ны өдрийн 41 дугаар тогтоолоор 244.8 сая төгрөгөөр хэвээр нь тодотгосон байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр 244.8 төгрөгийн төсөв баталснаас 228.5 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 16.3 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээс 228.6 сая төгрөгийн, орон нутгийн төсвөөс 16.3 сая төгрөгийн санхүүжилтийг авч, урсгал үйл ажиллагаанд 244.1 сая төгрөгийг зарцуулж, 0.7 сая төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулсан байна.

Нийт төсвийн 51.0 хувийг цалин, 5.6 хувийг НДШ-ийн зардал, 6.2 хувийг тогтмол зардал, 1.5 хувийг хангамж бараа материалын зардал, 34.5 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардалд зарцуулсан байна.

Тайлант онд Шүүхийн шийдвэрийн дагуу 2 ажилтанд ажлаас үндэслэлгүй халагдаж ажилгүй байсан хугацааны цалинд 3.6 сая төгрөг төлж үр ашиггүй зардал гаргасан байна. Газрын даргын “Өлгий Адвокат” ХХН-тэй байгуулсан гэрээний дагуу өмгөөлөгчийн хөлсөнд 4.0 сая төгрөгийг төлсөн бөгөөд гэрээг дүгнээгүй, хийж гүйцэтгэсэн ажлын тайлан байхгүй байгааг цаашид анхаарч ажиллах нь зүйтэй.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 244.1 сая төгрөг буюу 99.7 хувьтай байна.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд дээд шатны төсвийн захирагчаас 21.5 сая төгрөгийн санхүүжилт авч бараа үйлчилгээний бусад зардалд зарцуулсан байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2021 оны санхүүгийн тайланд холбогдох бүх мэдээллийг толилуулж, тодруулсан байна. Байгууллага үйл ажиллагаатай холбоотой тодорхой бус байдал үүссэн тохиолдол гараагүй байна.

АОУС 706.10-д заасан бусад асуудлын хэсэгт тусгахаар аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй байдал үүсээгүй болно.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2021 оны төсвийн нийт санхүүжилт 244.1 сая төгрөгөөс үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатай зардлыг хасахад 87.0 сая төгрөгийн зардлыг тэвчиж болох зардал гэж үзээд тогтоолын дагуу 8.7 сая төгрөгийг хэмнэх тооцоо гарч байгаа ба жилийн эцэст 0.7 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна. Үүнээс үзэхэд Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилт хангагдаагүй байна.

3.8 Аудитын гол асуудал

АОУС 701.8-д тодорхойлсон аудитын гол асуудлын хүрээнд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал гараагүй.

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ гараагүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т /шилэн дансны мэдээлэл/ тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тайлант хугацаанд оруулбал зохих 266.4 сая төгрөгийн 149 мэдээллээс 266,4, сая төгрөгийн 135 мэдээллийг хугацаандаа байршуулж, 14 мэдээллийг хугацаа хожимдуулж байршуулсан байна. Шилэн дансны 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй 10.0 сая төгрөгийн 1 гүйлгээг түүвэрлэн шалгаж үзэхэд зөрчил дутагдал илрээгүй. Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг 90.6% байршуулсан байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, батлагдсан төсвийн зарцуулалт нь төсвийн тухай хууль тогтоомжийг холбогдох заалтуудтай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж, нэмэлт санхүүжилтийн зарцуулалтыг цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалж дэлгэрэнгүй шалгах боломжгүй байсан тул гүйцэтгэлийн шалгалтаар дэлгэрэнгүй шалгах шаардлагатай. Энэ нь дараагийн аудитаар анхаарах асуудал байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар 12.3 сая төгрөгийн зөрчил илэрч 12.3 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, шилэн данстай холбоотой зөрчилд нэг зөвлөмж өгөв.

4.1 Залруулсан алдаа

Байхгүй

4.2 Төлбөрийн акт

Байхгүй

4.3 Албан шаардлага

Аудитаар 8.7 сая төгрөгийн зөрчилд арилгуулах албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар нь 2021 онд гүйцэтгэлээр нийт 244.1 сая төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулсан байна. Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.1-д зааснаар үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад батлагдсан төсвийн 10 хувь буюу 8.7 сая төгрөгийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал зардлыг төлөвлөн зарцуулаагүй, [Шүүхийн шийдвэрийн дагуу 2 ажилтанд ажлаас үндэслэлгүй халагдаж ажилгүй байсан хугацааны цалинд 3.6 сая төгрөг төлж үр ашиггүй зардал гаргасан байна.](#)

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т "Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ", 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн, 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 41 дүгээр зүйлийн 41.2.2-т "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах", 41.2.3-т "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах", Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.1-т "Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах" гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хууль, Засгийн газрын тогтоолыг хэрэгжүүлж төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өгөв.

4.4 Зөвлөмж

1. Илрүүлэлт

Шилэн дансанд тайлант хугацаанд оруулбал зохих 266.4 сая төгрөгийн 149 мэдээллээс 14 мэдээллийг хугацаа хожимдуулан байршуулсан байна.

1.2 Өгсөн зөвлөмж

Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын холбогдох заалтуудыг мөрдөн ажиллаж, шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	ГБХЗХГазар	2	12.3					1	12.3	1	